

## БЛОКЧЭЙН ТЕХНОЛОГИ СЭТГҮҮЛ ЗҮЙН ИРЭЭДҮЙ БОЛОХ НЬ

Б.Болд-Эрдэнэ\*

\*МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбар хариуцсан дэд захирал, доктор (Ph.D), дэд профессор

**Түлхүүр үг:** блокчэйн технологи, блокчэйний нөлөө, хөрөнгө санхүүжилт, мэдээллийн хамгаалалт, эх сурвалж, зохиогчийн нууцлал.

**М**эдээллийн технологийн хөгжил өөрчлөлт бүхэн нийгмийн харилцаа, хүмүүсийн амьдралын хэв маяг, соёл, хувь хүний үнэлэмж сэтгэл зүйд нөлөөлж ирсэн нь түүхийн бодит үнэн юм. Үүний шалтгааныг хүн төрөлхтөн орон зай, цаг хугацаа, мэдлэг оюуны хязгаарлагдмал, хараат байдлыг давах боломжийг бичиг үсэг, ном хэвлэл, радио, телевиз зэрэг мэдээллийг бүтээх, хадгалах, түгээх, дахин хуулбарлах технологи бий болсонтой холбон тайлбарладаг. Тиймээс ч хэрэгсэл бол нөлөө, эрх мэдлийн хүч хөдөлгүүр гэдэг утгаараа түгээн дамжуулж буй мэдээллээсээ илүү “утга агуулга, үзэл санаа” болж<sup>1</sup> байдгийг Канадын профессор Маршал Маклюэн бүр 1960-аад онд томъёолж байсан хэрэг.

Үнэхээр ч мэдээллийн технологи бүр өөрийн цаг үе, нийгэм, хүнийг “бүтээж” байсныг сонин, радио, телевизийн хөгжлийн эхэн, өсөлт, уналтын үе ба түүхийн гол томоохон үйл явдал хоорондын учир шалтгааны “холбоос”-оор нотолж болно. Товчхон хэлэхэд ном зохиол үзэл бодлын эрх чөлөөг,

радио олон нийтийн дарангуйллыг, телевиз хэт хэрэглээний түрэлтийг харин интернет банк санхүүгийн даяарчлалыг хүмүүний ертөнцөд дагуулсан.

Харин өнөөдөр аж үйлдвэржилтийн дөрөв дэх үеийн бодит хүчээр хүлээн зөвшөөрөгдсөн технологийн шинэ, хувьсгалч өөрчлөлт болох блокчэйний нөлөө нийгэм, эдийн засаг, санхүүгийн дэг журам, хэм хэмжээ, үнэлэмжид ямар үр дагавар, “хөдөлгөөн”-ийг өдөөх нь бүхний анхаарал, үзэл бодол, байр суурийн “төв” болоод байна.

Блокчэйн технологи нь төвлөрсөн бус, тархмал бүртгэл, өгөгдлийн дараалал хэлбэрээр мэдээлэл бүрийг нийтийн болон хувийн түлхүүр үгээр арван минут тутамд баталгаажуулдаг блок хэмээх зүйлд хадгалан өмнөхтэй нь гинжин хэлхээс үүсгэдэг нээлттэй эх, сүлжээ болно. Блокчэйний хамгийн түгээмэл хэлбэр нь биткойн, крипто мөнгөний сүлжээ бөгөөд санхүүгийн үйлчилгээ гүйлгээний хурд, хямд өртөг, аюулгүй байдалд урьд өмнө байгаагүй боломжийг бий болгохын хамт цахим довтолгоо, мэдээллийн хадгалалтын сүйрэлд өртөх төвлөрсөн “төв” үгүй гэдгээрээ мэргэжилтнүүдийн анхаарлыг татсан.

Хэрэглээний талаасаа ч блокчэйн нь хэн бүхэн үнэгүй татаж

ашигласнаар интернетээр гүйлгээ, үйлчилгээ, харилцаагаа өргөжүүлэх шинэ, олон хэлбэрийн аппликэйшн бий болгох, хэрэглэх боломжтойн зэрэгцээ хэрэглэгчийн компьютерт ачаалагдахаас бус төвлөрсөн өгөгдлийн сан гэж үгүй, мэдээлэл өгөгдөл нь сүлжээний орчинд оршин буй бол түүнийг хянах, өөрчлөх, дахин шинэчлэх боломжгүй тул өндөр нууцлал, хамгаалалттай технологи юм.

**Ү**нэхээр ч хувь хүний эрх чөлөө, бие даасан байдал, мэдээллийн өмчлөл хэмээх үнэлэмжийг ree-to-peeг платформ бодит зүйл болгож байгаа нь өнөөгийн цаг үе, нийгмийн онцгой чухал сорилт, зөрчлийг шийдэх ам-лалт гэдэг нь ойлгомжтой. Хүн бүр даяар сүлжээ-ний орчинд ямар нэгэн гуравдагч, хянагч, төвлөрсөн зуучлагч үгүйгээр мөнгө санхүү, мэдээлэл, үзэл бодлын солилцоо, харилцаа, түгээлтийн эрэлт хэрэгцээгээ хангана гэдэг ирээдүйг өөрчлөх их боломж билээ.

Төр засаг, үндэстэн дамнасан банк санхүүгийн бүлэглэл, улс төр шашны дарангуйллаас ангид хүн бүр хувийн нууц, эрх чөлөөгөө хамгаалан, хүссэн мэдээллээ олж, үзэл бодлоо илэрхийлэхийн хамт өөрийн буй бүхнээ баялаг болгож, өнөөгийн хуваарилалтын тэгш бус байдлыг өөрчлөхөд блокчэйн технологи нөлөөлнө. Тэгээд ч Нобелийн шагналт эдийн засагч Эрнандо дэ Сото “блокчэйнийг таван тэрбум хүнийг эдийн засагт оруулж, (гадуурхагдсан хөгжиж буй орны 5 тэрбум хүн.зох) төр иргэн хоорондын харилцааг өөрчилж, дэлхийн хөгжил цэцэглэлтийн шинэ платформ болж, хувь хүний эрхийг хамгаална<sup>2</sup> гэсэн байдаг. Ийнхүү блокчэйн технологийн онцлог, өнөөгийн дүр зургийг нэгтгэн үзвэл сэтгүүл зүйн ирээдүйд **хөрөнгө санхүүжилт, мэдээллийн хамгаа-**

**лалт, эх сурвалж, зохиогчийн нууцлал** гэсэн гурван боломжийг нээсэн аж.

### **Хөрөнгө санхүүжилт**

Интернетийн эхэн үеэс хөгжиж ирсэн онлайн сэтгүүл зүй нь хэрэглэгч хоорондын эргэх холбоо (инте-рактив), тэмдэгтийн өргөн зурвас (мульти-медиа), холбоост агуулгын гүн бүтэц (гипертекст) зэрэг шинэ онцлог, давуу чанарыг бий болгосон боловч мэдээллийн арилжаа, зохиогчийн эрхийн үнэлэмж, сайтын санхүүжилтийн асуудлыг шийдэхэд түвэгтэй, хязгаарлагдмал байсан юм. Тиймээс ч мэдээллийн хулгай, зохиогчийн эрхийн зөрчил болон ивээн тэтгэгч, реклам сурталчилгаанаас хараат байдал зэрэг бэрхшээл, сорилт өнөөдрийг хүртэл интернет сэтгүүл зүйн гол сэдэв болсоор байна. Ийнхүү худал төөрөгдүүлэлт, ёс зүйн гажуудал, үнэ цэнэгүй, хуулбарласан мэдээллийн хэт давхцал хийгээд хэрэглэгчийн үл итгэлцэл, хэт хэрэглээ-ний дарамт, үр нөлөөгүй харилцааны орчин зэрэг сөрөг үр дагаврын тухай шүүмж давамгайлах болсон.

Энэхүү шалтгаан үндэслэлээр ч контентийг ширхэгчлэн арилжаалах, хэрэглэгч хүн бүрийн эрэлтэд нийцсэн мэдээлийн үйлчилгээг нэвтрүүлэх зохиогчийн хөдөлмөрийг үнэлэх, сайтын санхүүгийн бие даасан байдлыг баталгаажуулах, төлбөрт мэдээллийн зах зээлийг бий болгох зорилт бас шаардлага урган гарсан хэрэг. Интернет сэтгүүл зүйн өмнө уламжлалт мэдээллийн хэрэгслийнх шиг захиалагч, хэрэглэгчдийнхээ санхүүжилтийн орчныг босгох, нөгөө талаас нийгмийн сүлжээний (Фэйсбүүк, Гүүгл) реклам сурталчилгааны орло-гын “их сав”-наас боломжит хувийг хүртэх гэсэн маркетингийн стратегийг

хэрэгжүүлэх алсын хараа оршиж байсаар ирсэн.

Энэ бүхнийг шийдэхэд биткойн хэлбэрийн крипто мөнгөний санхүүжилтэд суурилсан хэрэглэгч нэг бүрт контентийг ширхэгчлэн арилжаалах хийгээд эрэлт, хандалтын тоогоор шалгуур, үнэлэлтийн эрэмбэ тогтоох замаар сэтгүүлч, нийтлэлчдийг урамшуулдаг тогтолцоог бий болгох нь чухал болно. Мэдээж мэдээллийн сайтын эдийн засаг санхүүгийн байдал, ёс зүйн болоод агуулгын чанар цаашилбал сэтгүүлч, нийтлэлчдийн өрсөлдөөнийг дэмжих зэрэг олон эерэг нөлөө үзүүлнэ.

Ийм эхлэлийг “Participatory Politics Foundation” хэмээх ашгийн бус сангийн захирал асан Дэвид Моор Вашингтоны лобби бүлэглэлийн далд нууц үнэнийг нийтлэх зорилготой 20 гаруй мэдээний эх сурвалжид түшиглэсэн “Sludge” сэтгүүлийн мэдээллийг “Civil” блокчэйн платформд гаргах бэлтгэл хийснээр тавьжээ. Энэ бол Колумбийн Их сургуулийн онлайн сэтгүүл зүйн төвийн захирал Эмил Беллийн онцолсон “крипто мөнгөний технологи бодит санхүүжилтийн боломжийг бий болгох зорилготой сэтгүүлчдийн хамтын нэгдэл үйл ажиллагааны талбарыг нээх” ирээдүйг амалж буйн жишээ юм. “Civil” нь “ConcenSys” хэмээх Эфириум платформын програмчлалын ивээл ком-

панитай хамтран ажилладаг. Эфириумын цахим зоос крипто мөнгөний зах зээлд биткойны дараа хоёрдугаарт эрэмбэлэгддэг 2018 оны 4 сарын байдлаар 40 тэрбум доллараар үнэлэгддэг бөгөөд “Civil”-д нийтдээ 5 сая долларын хөрөнгө оруулалт хийсний 1 сая нь мэдээллийн эх сурвалжийн сан бүрдүүлэхэд зориулжээ<sup>3</sup>.

Ийнхүү “Civil” өөрийн цахим зоос CVL-ийг гаргаж хэрэглэгчдийн хандалт захиалгаар санхүүжүүлэх боломж болоод нэр хүндтэй сэтгүүлчдийг татах эхлэлийг тавьсан. Энэхүү төслийн зорилго нь реклам сурталчилгаа, хөрөнгө оруулагчдаас хараат бус зөвхөн хэрэглэгч, сэтгүүлчдийн блокчэйн технологи, крипто мөнгөний зах зээлийн зохицуулалтыг ашигласан чөлөөт хэвлэлийн платформыг бий болгожээ.

“Civil” нь орон нутгийн сурвалжлага, эрэн сурвалжлах болоод засгийн газрын бодлогын чиглэлээр мэргэшсэн сэтгүүлчидтэй хамтран ажиллах зорилгыг тавьсан нь орчин үеийн мэдээллийн хамгийн чухал төдийгүй нууцлал, хамгаалалт онцгой шаардлагатай асуудал, үйл явдлын тухай нийтлэл нэвтрүүлгийн эрэлт хэрэгцээтэй холбон үзжээ. Нөгөө талаар дээрхи сэтгүүл зүйн чиглэл, төрөл нь томоохон мэдээллийн компанийн төвлөрөл, дангаар ноёрхолд бүрэн автсан учраас

«

*Дээрх асуудлуудыг шийдэхэд биткойн хэлбэрийн крипто мөнгөний санхүүжилтэд суурилсан хэрэглэгч нэг бүрт контентийг ширхэгчлэн арилжаалах хийгээд эрэлт, хандалтын тоогоор шалгуур, үнэлэлтийн эрэмбэ тогтоох замаар сэтгүүлч, нийтлэлчдийг урамшуулдаг тогтолцоог бий болгох нь чухал болно. Мэдээж мэдээллийн сайтын эдийн засаг санхүүгийн байдал, ёс зүйн болоод агуулгын чанар цаашилбал сэтгүүлч нийтлэлчдийн өрсөлдөөнийг дэмжих зэрэг олон эерэг нөлөө үзүүлнэ*

»

бие даасан, мэдээллийн эрх чөлөөний орчин улам бүр хумигдаж байгааг нэмэн онцлох хэрэгтэй.

Чөлөөт хэвлэл, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь нийгмийн үнэлэмж, түүний бүлэг хүрээ хоорондын харилцааны дэг журам бол хараат бус байдал нь мэдээллийн байгууллагын эрхэмлэл, редакци сэтгүүлч уншигчдын дунд бодит үнэн, задлан шинжилсэн чухал, сонирхолтой нийтлэл нэвтрүүлгийн төлөө хийж буй гэрээний мөрдлөгийн үндэс суурь хэмээн ялган тодорхойлж болно. Чөлөөт хэвлэлд иргэний эрх ашиг, эр зориг, үнэлэмж оршдог бол хараат бус сэтгүүл зүйд эзэмшигч, сэтгүүлчийн нэр төр, үүрэг хариуцлага, ёс зүйн зарчим багтдаг.

Мэдээж хараат бус байдлын баталгаа нь санхүүгийн бие даасан байдал, хэрэгсэл ба хэрэглэгч хоорондын итгэлцэл, сэтгүүлчийн ажил мэргэжлийн нэр төрд нэгтгэгдэх билээ. Тиймээс ч “Civil” платформд крипто мөнгө төдийгүй доллар зэрэг валют бүр банкны картаар ч төлбөр хийх боломжийг нээсэн нь бие даасан сэтгүүл зүйн баталгааг бүрдүүлсэн хэрэг билээ. Гэхдээ крипто мөнгө эзэмшигч хэрэглэгч нь сэтгүүлчдийн бүтээлийг үндэслэн платформын зохиогчийн санд санал өгөх, бүр хэн нэгнийг дэвшүүлэх, хасах ч эрхтэй байдаг нь идэвхитэй, эргэх холбоот сэтгүүл зүйг дэмжих зорилготой нь холбоотой.

Өөр нэгэн “Civil” платформын адил мэдээллийн эх сурвалж нь сэтгүүлч, зохиолч Мари Бастилосын “PopuLa” хэмээх мэдээлэл соёл урлагийн сэтгүүл бөгөөд зохиогчдод мөнгөн урамшуулал өгөх крипто мөнгөний сүлжээг эхлүүлсэн оролдлого бий.

Блокчэйн технологийн хүрээнд тулгамдсан асуудал, сорилт байгааг нэн ялангуяа биткойны ханш унасан үйл явдлаар жишээлж болох ч “Civil” платформ нь ашиг орлогоос илүү мэдээллийн үнэ цэнэ, хэрэглэгчийн эрх ашгийг эрхэмлэдэгтэй холбон ирээдүй бийг хэлэх хэрэгтэй. Тэгээд ч “Civil”-ээс өмнө “Ройтерс” агентлагийн ерөнхий редактор асан Дэвид Шлезингер “Hubii” хэмээх блокчэйн технологид суурилсан мэдээллийн компани байгуулан крипто мөнгөний хөрөнгө оруулалт татах, өөрийн цахим зоос гаргах замаар сэтгүүлчдийг нэгтгэх эхлэл тавьсан. Энэхүү төслийн зорилго нь худал төөрөгдүүлэлтийн мэдээллээс татгалзах, мэргэжлийн нэр хүндийг өргөх болоод технологийн шинэчлэл, хөгжлийн ололтыг нэвтрүүлэхэд оршиж байв.

**М**онголын сэтгүүл зүйн хувьд дэлхийн шинэ туршлагыг эхлүүлэх боломж төдийгүй эрэлт хэрэгцээ байгаа нь тодорхой билээ. Нэн ялангуяа эрэн сурвалжлах сэтгүүл зүйн чиглэлээр крипто мөнгөний санхүүжилт бүхий бие даасан сэтгүүлчдийн төслийг ажил хэрэг болгох цаг болжээ. Эрэн сурвалжлагад сэтгүүлчийн мэдлэг чадвар, эр зоригоос илүү санхүү, эдийн засгийн бие даасан байдал, хараат бус байгууллагын оролцоо нөлөө чухал байдаг. Өдгөө бидэнд “Эрдэнэт” үйлдвэрийн 49 хувийн эзэмшил тойрсон дуулиан, “Эрдэнэт” үйлдвэрийг барьцаалан өмнөд Африкийн “Стандарт” банкнаас “Жаст”-ын захирлын авсан зээл, офшор бүсэд данс нээсэн эрх мэдэлтнүүдийн хэрэг зэрэг эрэн сурвалжлах сэтгүүл зүйн “нүд, чих” шаардлагатай томоохон асуудал олон нийт, нийгмийн хүлээлт, эрэлт дагуулсаар байна.

Тиймээс эдгээр олон асуулт, эргэлзээ, маргаан бүхий үйл явдлын үнэнийг хүргэх, олон нийтийн дэмжлэгийг татах нөгөө талаас хариуцлагатай, хараат бус сэтгүүл зүйг хөгжүүлэх хамгийн бодит боломж нь блокчэйн технологид суурилсан крипто мөнгөний санхүүжилт билээ. Мөн “Монгол тулгатны 100 эрхэм”, “Авьяаслаг монголчууд”, “Яг түүн шиг”, “100 чухал сэдэв” нэвтрүүлэг, Баабар, De Facto Жаргалсайхан зэрэг нийтлэлчдийн бүтээлийг нэгтгэсэн платформ бий болгох ч боломж бий.

“Civil”

платформ л гэхэд “Politico”, “Los Angeles”, “Times” сонин “New Yorker” сэтгүүлийн сэтгүүлчдийг нэгтгэсэн ба 200 орчим зохиогчийг нэгтгэсэн блокчэйн сэтгүүл зүйн редакци болой. Тиймээс ч бидэнд ийм блокчэйн технологийн хүрээнд мэргэжлийн стандарт, ёс зүй, ур чадвар бүхий сэтгүүлчдийн нэгдлийг виртуал гэрээ, хэрэглэгчийн төлбөрийн системийн зохицуулалттайгаар зохион байгуулах боломжтой билээ.

### Эх сурвалж

Блокчэйн технологи нь сүлжээ хэрэглэгчдийн төхөөрөмж бүрт агуулга өгөгдлийг хадгалдаг, нэгэн үйлчилгээ үзүүлэгчээс үл хамааралт, тархмал төвлөрсөн бус, мэдээлэгч ба хэрэглэгч хооронд гуравдах зуучлагч үгүй мэдээллийн санамсаргүй тохиолдлын

гинжин холбоост эх сурвалжийн орчныг бүтээсэн хэрэг. Тиймээс ч ил тод, өндөр хамгаалалт бүхий тул мэдээллийг хуулбарлах, хэрэглэх боломж хэрэглэгч бүрт нээлттэй ч засварлах, устгах, өөрчлөх боломж үгүй, цаг хугацааны дарааллаар эрэмбэлэгдсэн контент бүрийн дарааллыг “эвдэх” тооцооллын хүч хэнд ч үгүй юм.

Энэхүү онцлог, технологийн давуу байдал нь мэдээллийг хадгалах, түгээх найдвартай хамгаалалтыг сэтгүүлчид, хэрэглэгчид, нийгмийн бүх “нэгж, “эс”-д бодит зүйл болгосон.

Өдгөө төр засгийн төдийгүй хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшигчдийн хяналт, шахалт дарамтаас ангид, нийгэм, иргэдээс нууцалж буй баримт, үнэнг түгээх, хадгалах боломж бүрэн утгаараа нээгдлээ. Төвлөрсөн зохицуулалт, нэгэн үйлчилгээ үзүүлэгчээс хараат байдал эцэс болсноор мэдээлэл авах, мэдэх эрхийн эргэлзээтэй, зөрчилт асуудал хариултаа оллоо. Түүнчлэн крипто мөнгөний

«

*Блокчэйн технологи нь сүлжээ хэрэглэгчдийн төхөөрөмж бүрт агуулга өгөгдлийг хадгалдаг, нэгэн үйлчилгээ үзүүлэгчээс үл хамааралт, тархмал төвлөрсөн бус, мэдээлэгч ба хэрэглэгч хооронд гуравдах зуучлагч үгүй мэдээллийн санамсаргүй тохиолдлын гинжин холбоост эх сурвалжийн орчныг бүтээсэн хэрэг. Тиймээс ч ил тод, өндөр хамгаалалт бүхий тул мэдээллийг хуулбарлах, хэрэглэх боломж хэрэглэгч бүрт нээлттэй ч засварлах, устгах, өөрчлөх боломж үгүй, цаг хугацааны дарааллаар эрэмбэлэгдсэн контент бүрийн дарааллыг “эвдэх” тооцооллын хүч хэнд ч үгүй юм*

»

санхүүжилт нь худал, төөрөгдүүлэлтийн мэдээллийг шахан гаргах, сэтгүүлч ба хэрэглэгч хоорондын итгэлцэл, бодит үнэн, үнэ цэнэтэй харилцааг дагуулсан гэдгийг онцлох хэрэгтэй. Тийнхүү блокчэйн технологи нь сэтгүүл зүйг хэрэглэгч нийгэмдээ чиглэсэн үйлчилгээ, харилцаа байх

“хүч, нөөц”-ийг амлаж байгаа юм. Өнөөгийн байдлаар дэлхийд 18 сая крипто мөнгө байгаа нь 1994 оны интернет хэрэглэгчийн тоотой тэнцүү гэж үзэхэд ойрын арван жилд блокчэйн технологи нийгмийн амьдралд гүн бат нөлөөлөх нь ойлгомжтой.

Гэхдээ хамгийн чухал нь эх сурвалжийн аюулгүй байдал, нууцлалыг мэдээллийн орон зайд төгс хамгаалах боломжийг бүрдүүлдэнд блокчэйн технологийн ач холбогдол оршино. “Civil” платформын “цагаан ном”-д “Бид ухаалаг, виртуал гэрээгээр сэтгүүлчдийг ямарваа нэг цагдан хяналтаас ангид, оюун ухааны зохист мэтгэлцээн, харилцаанд нэгтгэж байна” хэмээн тунхагласан нь ч бодит үг юм. Нөгөө талаас нийгэм чанартай, үнэн бодит, олон талын, олон ургальч мэдээллийн эх сурвалжийг крипто мөнгөний шилжүүлэг хэрэглээгээр хадгалах, улмаар хөгжүүлэх эрх мэдлийг эрхшээн байгаа нь либерал, чөлөөт хэвлэлийн “мөрөөдөл” биелсэн хэрэг юм. Мэдээж хувь хүний үзэл бодлын эрх чөлөө, баталгаа ч давхар хангагдан, адил ойролцоо бүлэг хүрээтэйгээ нэгдэх, эрх ашиг, сонирхлоо илэрхийлэх болсноор мэдээллийн үнэ цэнэ, харилцан итгэлцэл өсөн нэмэгдэнэ.

Мэдээлэл, итгэлцэл, харилцаа гурав бол хүн төрөлхтний соёл иргэншлийг “хөдөлгөгч” хүч болохыг түүхийн аль ч үеийн баримт, үйл явдал, өөрчлөлт нотолно. Бичиг үсэг, ном хэвлэл, телевиз, интернет нь эдийн засаг, нийгэм, улс төрийн томоохон хөдөлгөөний шалтгаан байсныг, соёл иргэншлийг өөрчлөгч, шинэчлэгч хүч байсныг бид мэднэ. Нийгмийн талаас л гэхэд бичиг үсэг эзэнт гүрэн, шашны ноёрхол, шинжлэх ухааны эхлэлийг, сонин хэвлэл парламентийн тогтолцоо,

үзэл бодлын эрх чөлөө, аж үйлдвэржилтийн эринийг, радио олон нийтийн үзэл суртлын түрэлт хэрэглэний нийгмийн үндсийг, телевиз хэт хэрэглээ, билэгдлийн эдийн засаг, банк санхүүгийн ноёрхлыг, интернет даяарчлал, материаллаг бус үйлдвэрлэлийн тэргүүлэл зэргийг хүн төрөлхтний соёл иргэншил болгоход нөлөөлжээ.

Энэ бүхэн нь эцсийн дүндээ мэдээллийн хурд, хүрээ, нийгэм олон нийтийн итгэлцэлд суурилсан адилсал, дууриалал, харилцааны хувь хүн бүрт нөлөөлж буй байдлын үр дүн юм. Тэгэхлээр блокчэйн технологийн ирээдүй зөвхөн сэтгүүл зүй төдийгүй соёл иргэншлийн өргөн цар хүрээтэй, илүү үр ашигтай, хувь хүн бүрт хамаарах өөрчлөлт “хувьсгал”-д хүргэх нь зайлшгүй болно.

### **Зохиогчийн эрх, нууцлал**

Сэтгүүл зүйн мэргэжлийн нэр хүнд, нийгмийн дэмжлэг, үүрэг хариуцлага нь зохиогчийн итгэл үнэмшил, ур чадвар, чанартай бүтээлээс шууд шалтгаалдаг. Харин энэ бүх “нандин чанар”-ын үндэс суурь нь зохиогчийн эрхийн хамгаалал, нууцлал болно. Блокчэйн технологи нь зохиогчийн эрхийг хамгаалахын сацуу үнэлэх төлбөр тооцооны гүйлгээг хангадаг. Ийнхүү үнэ төлбөрийн крипто мөнгөний бодит орчин бүрдсэнээр үнэн, үнэ цэнэтэй, эрэлт хэрэгцээ бүхий нийтлэл нэвтрүүлэг бүтээх өрсөлдөөн, санхүүгийн баталгаа сэтгүүлчдийн ажил мэргэжлийн нэр хүнд, чанарыг өргөх хөшүүрэг болно. Бас үндэсний төдийгүй дэлхийн зах зээлд гарах, бусадтай хамтрах, олон эх сурвалжийг төлбөртэй ашиглах, өөрийн бүтээлийг арилжаалах гээд эерэг үр дагаврууд үргэлжилнэ. Мэдээллийг ширхэгчлэн хувь хэрэглэгч нэг бүрт борлуулах найдвартай, шуурхай, “тунгалаг”

санхүүгийн үйлчилгээ нь сэтгүүлчийн ёс зүй, нийгмийн хариуцлагаа мэргэжлийн “стандарт” болгох түлхэц, шалгуурын түвшинд хүргэнэ. Ил тод, нээлттэй, хэрэглэгчиддээ тайлагнадаг, захиалга хандалтаар санхүүждэг тогтолцоо нь өдгөө сэтгүүл зүйн сорилт болоод байгаа зохиогчийн эрхийн зөрчил, маргаан мэтгэлцээнийг шударгаар шийдэх гарц мөн. Мэдээллийн хуулбарлалт, хулгай, төөрөгдүүлэлт зэрэг асуудал нь багагүй хугацаанд Монголын сэтгүүлчдийн дунд эрс шүүмжлэл, зөрчлийн жишээ, үндэслэл болсоор ирсэн. Үүнийг шийдэх хялбар бөгөөд үр ашигтай арга нь нийтийн (томоохон төвлөрсөн бус) хувийн (хязгаарлагдмал хүрээний, зөвхөн итгэмжит гишүүд дунд) зөвшөөрөгдсөн (нийтийн ба хувийн хосолмол) блокчэйн технологийг сэтгүүлч, нийтлэлч, мэдээллийн байгууллага бүр ашиглахад оршино.

**З**охиогчийн нууцлал нь мэдээллийн нээлттэй эх, төвлөрөл үгүй тогтолцоо, технологийн хамгааллаар баталгааждаг. Блокчэйн нь криптографийн шифрлэлтээр хамгаалагдсан блокуудын төвлөрсөн бус peer-to-peer сүлжээгээр хянан баталгаажуулдаг, цахим тодорхойлолт, хувийн нууцлалын технологийн дэвшил гэдгээрээ сэтгүүлчийн зохиогч, эх сурвалжийн нууцлалыг бүрэн хангаж байгаа юм.

Сэтгүүл зүйн түүхэнд Жулиан Асанж, Эдвард Сноуден нар АНУ-ын засгийн газрын нууц мэдээллийг ил болгосноор дэлхий дахины улс төр, олон улсын харилцаанд томоохон “хөдөлгөөн” оруулсныг бид мэднэ.

Гэхдээ энэхүү АНУ-ын цэрэг дайн, гадаад бодлогын “үнэн”-ийг илчилсэн мэдээллийн нууцлал, зохиогчийн эрхийг блокчэйн технологиор хамгаалсан бол илүү их үр дүн, өөрчлөлт дагуулах байсан нь тодорхой. Үүний нэгэн адил Монголын нийгэм, эдийн засаг, улс төрийн “сүүдэр”-ийг эрэн сурвалжилж, илчлэн гаргахад блокчэйн технологи томоохон боломжийг нээнэ гэдэгт эргэлзэх зүйлгүй.

Эцэст нь тэмдэглэхэд блокчэйн технологи сэтгүүл зүйн үүрэг, байр суурь, үүрэг хариуцлага, мэдээлэл олж авах, түгээх эрх, сэтгүүлчийн ур чадвар гээд бүхнийг өөрчилж байна. Тиймээс ч хувийн өмгөөлөгч, өөрийн данс, гэр бүлийн сэтгэл зүйч гэдэг шиг сэтгүүлчтэй болох цаг хүн бүрт ирж байгааг блокчэйн технологийн түрэлт, нөлөө нотолж байна.

### Ишлэл

- <sup>1</sup> Маклюэн.М Понимание медиа:Внешние расширения человека. М. 1999. стр 37.
- <sup>2</sup> Дон, Алэкс Тапскотт Блокчэйний хувьсгал. УБ. 2018. 383 тал.
- <sup>3</sup> <https://civil.co/featured-stories/>

### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Маклюэн М. 1999. Понимание медиа: Внешние расширения человека
2. Дон, Алэкс Тапскотт. 2018. Блокчэйний хувьсгал. УБ.
3. [www.civil.co](http://www.civil.co)

### Abstract

In this article, we discuss about features of block chain technology and its' effect on society and journalism. To sum up its' efficiency generally, block chain technology brings three emphasizing opportunities (funding, information security and encryption of resource & authors) for the future of journalism.